



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ НОМЫН САНГИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

(2020-2024 ОН)



Улаанбаатар хот

БАТЛАВ. ЗАХИРАЛ



Б.ИЧИНХОРЛОО

**МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ НОМЫН САНГИЙН
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ
/2020-2024/**

УЛААНБААТАР ХОТ
2019

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ НОМЫН САНГИЙН СТРАТЕГИ ТӨДӨВЛӨГӨӨ / 2020-2024 /

I БҮЛЭГ. Ерөнхий танилцуулга

1.1 Стратегийн тухай товч мэдээлэл

Энэхүү Стратеги нь Монгол Улсын Үндэсний номын санг хоёр үе шаттайгаар 2020-2024 онд шинэчилж хөгжүүлэх бодлого, авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлно.

Монгол Улсын Үндэсний номын сан 2020 онд шинэ барилгад орох төлөвлөгөөтэй байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар тус Номын санд 21 дүгээр зууны хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг хангасан технологид суурилсан үйлчилгээ нэвтрээгүй, уламжлалт үйлчилгээ төдийхнөөр аргацааж, үнэт ховор хуучин номын хадгалалт хамгаалалт ч хүндхэн нөхцөлд байгаа юм. Стратегийн эхний шатанд шинэ байранд орох хүртэл (шилжилтийн үе) үйлчилгээний хуучин загварыг халж, шинэчилсэн үйлчилгээг турших, боловсон хүчнээ бэлтгэх, техник технологийн шинэчлэл хийн шинэ байранд шууд ажиллах загваруудыг бэлэн болгох, сүүлийн шатанд шинэ байранд 1-2 жил тэдгээр өөрчлөлтөө туршиж хэрэгжүүлэх (туршилтын үе) үйл ажиллагааг багтаасан энэхүү стратегийг боловсрууллаа.

Мэдээллийн эрин зуунд дэлхийн ихэнх улс орны Үндэсний номын сан тухайн орны бичиг соёлын өв, оюуны үнэт бүтээлийг хадгалан хамгаалж хойч үедээ үлдээх үүргээс гадна хэрэглэгчдээ өөрийн орны болон дэлхийн бусад орны мэдлэг мэдээлэлтэй холбогч гүүр болон ажилладаг. Энэ хариуцлагатай үйл ажиллагаагаа урт, богино хугацааны стратеги хөтөлбөрөөр дэвшүүлэн төрийн бодлогодоо тусгуулж, хамтран ажиллагсад, үйлчлүүлэгчиддээ ил тод танилцуулан орчин үеийн мэдээллийн технологид суурилсан шинэ төрлийн үйлчилгээ, хэрэглээг бий болгоход зарцуулах хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлж байна.

Монгол Улс “...МХХТ-ийг хөгжлийн хурдасгуур болгон мэдлэг оюунд тулгуурласан нийгмийн суурийг тавих”¹ Засгийн Газрын зорилтыг хэрэгжүүлэхэд номын сангийн нийгэмд гүйцэтгэх үүрэг асар их бөгөөд, нөгөө талаас хэрэглэгчдэд шаардлагатай мэдлэг мэдээллийн сан бүрдүүлж найдвартай, хүртээмжтэй, хялбар, хямд аргаар түгээх нь Үндэсний номын сангийн тулгамдсан асуудал болоод байна. Иймээс Үндэсний номын сангийн хөгжилд шинэ боломж, өөрчлөлт авч ирэх 2 үе шаттай урт хугацааны баримт бичгийг боловсруулав.

1.2 Стратегийн үндэслэл

Монгол Улс 20- иод жилийн хугацаанд улс орны нийгэм, эдийн засгийн бүхий л салбарт өргөн хүрээний өөрчлөлт, шинэчлэлт хийгдэж ирлээ. Улс орны ирээдүйн хөгжлийн чиг хандлагыг “Монгол Улсын Үндэсний хөгжлийн цогц бодлого” (2017) зэрэг хөгжлийн тулгуур баримт бичгүүдэд “Үндэсний өв соёл, үнэт зүйлээ даяаршлын чиг хандлагад нийцүүлэн хөгжүүлж, эдийн засгийн өсөлтийг хангах мэдлэгт суурилсан эдийн засагт шилжин мэдээлэлжсэн нийгэм байгуулахын зэрэгцээ хүн амд соёл урлагийн үйлчилгээг хүртээмжтэй чанартай хүргэж, иргэдийн оюуны хэрэгцээг хангахад дорвитой ахиц гаргана” гэж тодорхойлжээ. Түүнчлэн Засгийн Газрын 2016-2020 оны хөтөлбөрт⁴ нийт сум, суурин газрын 60 гаруй хувийг хамраад байгаа мэдээлэл харилцаа холбооны сүлжээг өргөтгөн бүх орон даяар ялангуяа алслагдсан сум, баг, хилийн боомтуудын цэгийг хамарсан өндөр хурдны мэдээллийн дэд бүтэц болгохоор тусгагдаад байна. Монголын 1,5 сая х.д.км. газар нутгийг хамрах

Мэдээллийн технологийн энэхүү дэд бүтцийн үр өгөөжийг бараг бүх нийтээр (98%) бичиг үсэгт тайлагдсан, 30 гаруй хувь нь 18-аас доош насны 2,7 сая хүн⁵ хүртэх болно. Засгийн Газрын энэхүү зорилтыг, мэдлэгт суурилсан эдийн засагт шилжих төрийн бодлогыг амжилттай хэрэгжүүлэхэд хөдөө, орон нутгийн нийтийн болон их дээд сургуулийн номын санг мэргэжил арга зүйн хувьд тэргүүлэн удирдах учиртай Үндэсний номын сан ихээхэн үүрэгтэй билээ.

Монгол Улсын Засгийн Газрын 1994 оны 23-р тогтоолоор уг Номын санг төрийн өмчийн номын сангуудыг мэргэжлийн удирдлага, арга зүй, мэдээллээр хангах үүрэг бүхий бие даасан үйл ажиллагаатай **Улсын төв номын сан** болгосон бол мөн 2004 оны 196-р тогтоолоор бичгийн үнэт дурсгалыг хадгалах, хамгаалах, улсын хэмжээний номын сангуудыг мэргэжил арга зүй, мэдээллээр хангах, ном хэвлэлийн нэгдсэн сан байгуулж үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий **Үндэсний номын сан** болгож статусыг өөрчилсөн билээ. Гэсэн хэдий ч 1990 оноос хойшхи шилжилтийн үеийн төсөв, санхүүгийн хомсдол нь Монголын боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын хөгжлийг удаашруулж түүний дотор номын санг ном уншуулах үйлчилгээнээс өөр илүү зүйлгүйгээр арай ядан авч үлдэхэд хүргэсэн юм.

Монгол орны эдийн засаг сүүлийн 2-3 жилд мэдэгдэхүйц өсч (2007 онд хамгийн өндөр -9.9%⁶) эхэлсэн хэдий ч дэлхий нийтийг хамарсан санхүү, эдийн засгийн хямрал улс орны бүх салбарт хүндээр тусч байна. Засгийн Газар эрдэс баялгийн нөөцөө зөв цаг үед нь зохистой ашигласнаар хямралыг даван туулж, мэдлэгт суурилсан нийгмийн хөгжлийг дэмжих төрийн бодлогоо хэрэгжүүлэхийг зорьж байгаа хэдий ч дээрх хямралын улмаас УИХ Үндэсний номын сан болон нийтийн номын сангуудын 2009 оны шинэ ном, хэвлэл хийгээд шинэ техник хэрэгсэл авах төсвийг тэглэв.

ЮНЕСКО-гийн тодорхойлсноор (Schick, 1971:8-9)⁷, Үндэсний номын сан тухайн орны хэвлэлийн чухал бүтээгдэхүүний хувийг заавал авах хуулийн болон бусад зохицуулалтын хүрээнд цуглуулах, гадаад хэлээр хэвлэгдэн гарсан өөрийн орны тухай ном, мөн гадаадын зохиол бүтээлийг төлөөлөх томоохон сан хөмрөгийг бүрдүүлэн хадгалж хамгаалах, үндэсний ном зүйн бүртгэл хийх, үндэсний нэгдсэн каталогийг бүрдүүлэх наад захын үндсэн үүргийг хүлээх ёстой. Түүнчлэн Үндэсний Номын сан орон бүрийн онцлогоос хамааран үүрэг зорилго нь ижил байдаггүй ч олонхи нь “үндэсний соёлын өвийг цуглуулж, хадгалан хамгаалах, сурталчлан таниулж түгээх” гэсэн нэг гол нийтлэг үүрэг хүлээдэг байна.

Ийм үүрэг хүлээсэн Монгол Улсын Үндэсний номын сан 1951 онд одоо байрлаж буй байрандаа 500 мянган номтой нүүж ирж байсан бол сан хөмрөг нь эдүгээ гурван саяас давжээ. Ашиглалтад орсноос хойш 1977, 1990, 2000 онуудын гурван удаагийн урсгал засвараас өөр их засварт орж, өргөтгөл хийгдээгүй Номын сангийн уг байрыг 2005-онд Улсын мэргэжлийн хяналтын газар шалгаж “Барилгад моралийн элэгдлээс шалтгаалж, даацын бүтцүүдэд нормоор зөвшөөрөгдөх хэмжээнээс өргөнтэй ан цавууд гарсан, орчин үеийн шаардлагад нийцсэн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай цахилгааны хангамж, аюулгүйн техникийн норматив хангагдаагүй, бичил цаг уурын үзүүлэлтүүд эрүүл ахуйн зөвшөөрөгдөх хэмжээнд хүрэхгүй, ажлын орон зай, талбай стандартын шаардлагын хэмжээнд хүрэхгүй байна.” гэсэн дүгнэлт гаргасан. Түүнчлэн тус номын сангийн үйл ажиллагаанд одоо хэрэглэгдэж байгаа техник, тоног төхөөрөмжийн хүрэлцээ хангамж муу, хүчин чадал дутмаг, мэдээллийн технологийн дэд бүтэц бүрэн бий болоогүйгээс гадна технологийн эрин зуунд номын санчдыг давтан болон орчин үеийн технологийн дэвшил ашиглах тасралтгүй сургалтыг явуулах системтэй бодлого илт үгүйлэгдэж, нөөц хөрөнгө ч байхгүй байна.

Ийм ч учраас МУ-ын Ерөнхийлөгч Үндэсний Номын Сангийн шинэ ордон барьж, үйлчилгээг нь шинэ шатанд гаргах, холбогдох зардал, хөрөнгийг Кувэйт Улсын буцалтгүй тусламж болон улсын төсөвт тусгах замаар шийдвэрлэх тухай зарлигийг 2008 онд гаргасан юм. Энэ зарлиг МУ-ын Засгийн Газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.2.27-д “Үндэсний номын ордны шинэ цогцолбор барина. Сумын номын сангийн фондыг жил бүр баяжуулж, уншигчдын тоог

нэмэгдүүлнэ...”⁹ гэж тусгалаа олсон буй. Өнгөрсөн оны зургаан сард номын ордон барих газрын асуудал шийдэгдэн суурь тавих ёслол болж БСШУ-ны сайд “Номын сангийн энэхүү шинэ барилга нь чөлөөт зах зээлд шилжсэнээс хойш боловсрол, соёлын салбарт хийж байгаа хамгийн үр дүнтэй хөрөнгө оруулалт болно” гээд цааш нь “шинэ номын сан нь хүн бүрийн очих дуртай орчин үеийн, шинэ технологи, тоног төхөөрөмжтэй боловсролын ордон байх болно гэж найдаж байна”¹⁰ гэжээ.

Тус Номын Сан нь технологийн эринд хэрэглэгчдийнхээ хэрэгцээ шаардлагыг хангаж чадах дижитал дэд бүтцэд түшиглэсэн шинэ үйлчилгээ үзүүлж чадахгүй байгаагаар үл барам бусад орны Үндэсний номын сангийн гүйцэтгэдэг түгээмэл үүргийг ч гүйцэтгэхэд нөөц, хүчин чадал нь шавхагдаж байна. Иймээс Үндэсний Номын Сангийн үйлчилгээ, орчинд эрс шинэчлэлт хийх нь Монголын номын сангуудын, цаашлаад Монголчуудын оюуны хөгжил, сурах мэдэх, судалгаа шинжилгээ хийх ажилд маш том дэвшил гаргах болно.

Өөрчлөлтийг эхлүүлэхээр Үндэсний номын санд шинэчлэл, хөгжил дэвшил авч ирэх хоёр үе шаттай (1-р үе шат 2020-2022; 2-р үе шат 2023-2024) стратегийг 2020-2024 онд хэрэгжүүлэхээр боловсрууллаа. Бид Үндэсний номын сангийн тэргүүлэх үүргээ гүйцэтгэж, 21-р зууны хэрэглэгчдийн хэрэгцээ, шаардлагыг хангах шинэ үйлчилгээг энгийн, найдвартай аргаар хүргэх шинэ ур чадвар, шинэ бүтэц, улс төрийн шийдвэр, тогтвортой ажиллагааг хангах хууль эрх зүйн орчин, шинэ хөрөнгө оруулалт шаардагдах нэгдмэл зорилго, зорилт дэвшүүлж байна. Энэ бүхний үр дүнд “мэдлэгт суурилсан эдийн засгийг хөгжүүлэх” төрийн бодлого хэрэгжиж түүний үр ашгийг Монголын бүх хэрэглэгчид хүртэж, эцсийн дүндээ Монгол Улсын хөгжилд тодорхой хэмжээгээр хувь нэмэр оруулах болно гэж итгэж байна.

1.3. Номын сангийн өнөөгийн байдал

Үндэсний Номын Сан 1921 онд Судар бичгийн хүрээлэнгийн дэргэд байгуулагдаж, 1924 оноос гадаад солилцооны ажиллагаа эхэлсэн ба 1991 онд Олон Улсын Номын Сангийн Холбоонд (ОУНСХ) гишүүнээр элсэж, өнөөгийн байдлаар 70 гаруй орны 100-гаад номын сантай ном, хэвлэл солилцож байна. Монгол Улсын Үндэсний номын сангийн дүрэмд тус Номын сангийн зорилгыг “...гар бичмэл, барын ном, эрдмийн зэрэг хамгаалсан бүтээл, Монгол Улсад хэвлэгдсэн ном, сонин сэтгүүл болон хэвлэлийн бусад бүтээгдэхүүн, чухал хэрэгцээтэй гадаадын ном зохиол, тогтмол хэвлэлийг бүрдүүлэн хадгалах, бүртгэл мэдээллийн сан бий болгох, уншигчдад шуурхай үйлчлэх, бусад номын сангуудыг мэргэжил арга зүйн удирдлага, мэдээллээр хангах”¹¹ гэж тодорхойлсон байдаг.

Номын сангийн одоо байгаа гурван сая гаруй ном бүтээлээс нэг сая нь үнэт болон ховор нандин ном судар, гар бичмэл түүний дотор дэлхийд цорын ганц хувь “Есөн эрдэнийн Ганжуур”, 18-р зууны үед цэвэр мөнгөн хуудсан дээр алтаар бичигдсэн “Сандуйн жүд”, Энэтхэгийн гүн ухаантан Нагаржунайн хэрэглэж байсан дал модны навчин дээр бүтээгдсэн “Жадамба” зэрэг үнэт, ховор бүтээлтэй улсын хамгийн том номын сан юм. Түүнчлэн номын сангуудад мөрдөгдөх эрх зүйн баримт бичиг, дүрэм журам боловсруулах, мэргэжлийн ном, гарын авлага, ном зүйн бүтээлүүдийг бэлтгэн гаргах, номын санчдын сургалтыг зохион байгуулж, улсын бүх төрлийн 1500-аад номын санд зөвлөгөө өгч ажилладаг мэргэжил арга зүйн төв юм.

НОМЫН САНГИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ

Фонд	8	
Уншлагын танхим	6	
Хэлтэс	5	Мэдээлэл арга зүй, эрдэм шинжилгээ Уншлага үйлчилгээ Сан хөмрөг хадгаламжийн Ном бүрдүүлэх, боловсруулах, солилцох Захиргаа аж ахуй
Сан хөмрөг	3 сая	
Үйлчлүүлэгчдийн тоо	60 мянга (жилд)	
Удирдах ажилтан	1	
Мэргэжлийн ажилтан	55	
Туслах ажилтан	20	
Нийт компьютер	40	
Нийтийн хэрэглээнд	21	

Номын сан 2001 оноос Интернэтэд холбогдсон. Сүүлийн 10-аад жилд гурван сая сан хөмрөгийн цаасан каталогийг цахим каталогт шилжүүлэх ажил эхлүүлж одоогоор 300,000 орчим ном бүртгэгдээд байна. Үндэсний номын сан үүрэг, зорилгынхоо дагуу 1990 он хүртэл үндэсний хэмжээний нэгдсэн /цаасан/ каталогийг зохион байгуулах ажлыг гүйцэтгэж байсан ба шилжилтийн үеийн төсөв, санхүүгийн хомсдлоос Сангийн Яамнаас тус каталогийг хариуцан хийх ажилтны төсвийг хасч энэ үйл ажиллагаа зогссон. Одоогоор номын сангууд тус тусдаа каталоги зохион байгуулалт, лавлагаа номзүйн ажлыг бие даан хийж байгаа нь эцсийн дүндээ харин ч илүү төсөв хөрөнгө, хүн хүч шаардсан ажил болоод байгаа юм. Иймээс шинэ стратегийн хүрээнд Үндэсний нэгдсэн электрон каталог зохион байгуулах ажлыг үе шаттайгаар хийхээр төлөвлөж байна.

Үндэсний номын сангаар үйлчлүүлүүлэгчдийн тоо Улаанбаатар хотын нийт хүн амын дөнгөж 5 хувьтай тэнцэнэ. Номын сангийн одоогийн үйлчилгээ нь гол үйлчлүүлэгчид болох оюутан, эрдэмтэн судлаачдын хэрэгцээ шаардлагыг бүрэн дүүрэн хангаж чадахгүй (судалгаанд хариулсан хүмүүсийн 60 орчим хувь¹² нь) байгааг судалгааны дүн харуулсан. Зөвхөн хэвлэмэл бүтээлийн сангаар танхимд үйлчлэхээс өөр төрлийн, дижитал дэд бүтцэд суурилсан энгийн хялбар, шинэ үйлчилгээ хөгжүүлж, электрон нэгдсэн хайлтын системтэй болж, орчин үеийн

¹¹ Монгол Улсын Үндэсний Номын сангийн дүрэм. 2005 оны 2-р сарын 08

¹² Үндэсний номын сангийн хэрэглэгчдийн судалгаа. 2009 оны 02 сар

технологийн дэвшил нэвтрүүлэхгүй бол ойрын хэдэн жилдээ Интернэтийн хайлтаас илүү мэдээлэл хүртээж үйлчлүүлэгчдийн тоогоо нэмэгдүүлэх найдваргүй байна.

Одоогийн байдлаар тус Номын сан монгол гар бичмэл номын болон төвд судрын гэсэн хоёр төрлийн дижитал сантай. Энэтхэгийн Засгийн Газрын дэмжлэгтэйгээр 3 нэрийн 385 боть монгол гар бичмэл номыг, Америкийн ACIP хөтөлбөртэй хамтран 2 нэрийн 226 боть, 150 төвд лам нарын 2840 төвд ном судрыг тоон хэлбэрт шилжүүлсэн хэдий ч олон нийтэд ашиглуулах, үзүүлж харуулах тоног төхөөрөмж дутагдалтайгаас үйлчлүүлэгчдэд хүртээмжгүй /ашиглуулахгүй/ байгаа. Үнэт, ховор номыг дижиталчилах ажил ч эхлэлийн шатандаа байна.

Үндэсний номын сан eIFL.net байгууллагын дэмжлэгтэйгээр 2008 онд байгуулагдсан Монголын номын сангуудын Консорциумын гишүүн болж хэрэглэгчиддээ бусад орны цахим мэдээллийн чухал сангуудыг ашиглах боломж олгохыг зорьж байна. Гэхдээ соёлын үнэт ховор өв сан, хэрэглэгчдийн шаардлагаар өсөн нэмэгдэх оюуны бүтээлийг хадгалан хамгаалахын хамт хэрэглэгчдэд хүртээмжтэй болгох, ялангуяа мэдээллийн технологид суурилсан шинэ үйлчилгээгээр өргөтгөхөд Номын сангийн одоогийн байшинг шинэчлэн засварлаад ч хангалтгүй, шинэ байр шаардлагатай болно.

Засгийн Газраас 2005 онд тус номын сангийн статусыг шинэчлэн Үндэсний Номын Сан болгон бүтэц зохион байгуулалтыг өөрчлөх, фондыг төрөлжүүлж, үйлчилгээг өргөтгөх тогтоол гаргасан боловч өнөөдрийг хүртэл тэрхүү шинэчилсэн бүтцээр ажиллах төсөв, хөрөнгийг хуваарилаагүйгээс уг тогтоол бодит амьдралд хэрэгжиж эхлээгүй байна. Нөгөө талаас, Үндэсний номын сан болохтой холбогдуулан 2005 онд Номын сангийн дүрмийг шинэчлэн боловсруулж, уг дүрмийн 2.4, 2.8 ба 2.6-д “Номын сангийн үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт технологи нэвтрүүлэх; Номын санг автоматжуулах, номын сан-номзүйн чиглэлээр судалгааны ажил хийх” гэсэн чухал заалтууд орсон боловч эдгээр заалтуудыг нь байнгын нэмэлт хөрөнгө оруулалт, тодорхой бодлогын зохицуулалтгүйгээр Үндэсний Номын сан дангаараа хийж гүйцэтгэх боломжгүй зүйл юм.

Стратеги төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг дэс дараатай хийж гүйцэтгэснээр Үндэсний номын сан өөрийн дүрмийн хүрээнд хүлээх ёстой түгээмэл үүргээ биелүүлж, Монгол Улсын Засгийн Газраас гаргасан тогтоол шийдвэр, ОУНСХ, ЮНЕСКО-гоос гаргасан удирдамжийг хэрэгжүүлэх боломжтой болно. Стратегийн зорилтуудыг амжилттай хэрэгжүүлэхэд Монгол Улсын Засгийн Газар, БСШУЯ-ны бодлого, хөрөнгө оруулалт шийдвэрлэх үүрэгтэй. Түүнчлэн олон улсын ижил төстэй байгууллагын сайн туршлага, хамтын ажиллагаа, сайн санааны болон олон улсын ивээн тэтгэх байгууллагын тус дэмжлэг ч шаардлагатай байна.

1.4 Стратегийн тэргүүлэх чиглэл

1.4.1 Сан хөмрөг, түүнийг хүртээмжтэй болгох стратеги/Content & Access Strategy/

Үндэсний Номын сан 2010-2016 онд сан хөмрөгийн баяжилт хийхдээ нэн тэргүүнд:

- Уншигч хэрэглэгчдийнхээ хэрэгцээ шаардлагыг харгалзах
- Хэвлэмэл сан хөмрөгөө улам чанаржуулах ба электрон агуулгыг шинээр бүрдүүлж нийтэд хүртээмжтэй болгоход түлхүү анхаарах
- Хадгалалт хамгаалалт, түгээлтийн найдвартай байдлыг хангахыг чухалчилна.

Энэ бүхнийг харгалзан цаашид Номын сангийн сан хөмрөгийг шинэчлэн баяжуулах чиглэлээр дорвитой ажлууд хийгдэнэ. Тухайлбал:

- Үнэт ховор эртний гар бичмэл ном

- Орчин үеийн хэвлэмэл ба дижитал бүтээгдэхүүн, түүний дотор Монгол хэл дээрх дижитал мэдээллийн сан
- Монгол судлалын холбогдолтой гадаад ном хэвлэл
- Нобелийн шагналтнуудын бүтээл
- Дэлхийд гарч байгаа шинжлэх ухааны орчин үеийн ололт, нээлтийн бүтээл
- Эрдэм шинжилгээ судалгааны электрон сангуудыг бүрдүүлж хэрэглэгчдийн хүртээл болгоно.

Үнэт, ховор эртний гар бичмэлүүдийг баяжуулахдаа хүмүүсийн гар дээр байгаа бүтээлүүдийг эрэн сурвалжилж биет байдлаар болон электрон хуулбарыг олж цуглуулах бодлого баримтлана.

Заавал авах номын тухай МУ-ын Ерөнхийлөгчийн зарлигийг хууль эрхийн акт болгоход БСШУЯ, Номын сангийн консорциумтай хамтран нөлөөллийн үйл ажиллагаа явуулж эрх зүйн акт гаргуулах замаар Монгол Улсад шинээр хэвлэгдэж байгаа цаасан болон электрон номын хувийг цуглуулах ажлыг баталгаажуулна.

Монгол судлалын чиглэлээр судалгаа шинжилгээний ажил хийдэг гадаад, дотоодын эрдэмтэн судлаачдын гол сан хөмрөг Үндэсний номын санд байдаг бөгөөд түүнийг баяжуулж чанаржуулах нь Номын сангийн үндсэн үүргийн нэг хэвээр байна.

Даяаршин, технологижиж байгаа мэдээллийн эрин зуунд дэлхийн бусад орны судалгаа, шинжилгээний электрон санг сонгож, захиалан үйлчлүүлэгчиддээ хүргэх бэлтгэл ажлыг энэ стратегийн эхний шатанд хангаж, хоёр дахь шатнаас хэрэгжүүлж эхэлнэ. Тухайлбал, электрон мэдээллийн EBSCO, JSTOR, SPRINGER, ELSEVER зэрэг эрэлт ихтэй, дундаа ашигладаг сангуудыг эхний ээлжинд хөнгөлөлттэй үнээр захиалах арга зам хайна.

Дээрх шинэ болон шинэчилсэн сан хөмрөгөө дараах арга замаар хэрэглэгчиддээ хүргэнэ. Үүнд:

- Төрөлжсөн уншлагын танхимаар /одоо байгаа танхимуудыг төрөлжүүлнэ./
- Онлайнаар /Хэрэглэгчийн эрхээр гаднаас, Номын сан дотроос чөлөөтэй/
- Ханагүй үйлчилгээ /гэрээр ном олгох, зөөврийн/
- Номын сан хоорондын ном солилцоогоор
- Төрөл бүрийн арга хэмжээгээр /үзэсгэлэн, лекц хэлэлцүүлэг, номын нээлт, ТВ нэвтрүүлэг, номын дуудлага худалдаа гэх мэт/
- Орчин үеийн харилцаа холбооны бусад хэрэгслүүдээр /ном унших дэлгэц, iphone, iriver, гар утсаар сурталчилгаа хийх зэрэг/.

Нэгэнт бүрдүүлсэн сан хөмрөгөө хэрэглэгчдэд хүртээмжтэй болгоход үндэсний гар утасны компаниуд, төрийн болон төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллага, бизнесийн бусад түнш байгууллагуудтай санамж бичиг, гэрээ хэлэлцээр хүрээнд харилцан ашигтай хамтарч ажиллана.

1.4.2 Үйлчлүүлэгчид ба Хамтын ажиллагааны стратеги

Стратегийн хүрээнд дэвшүүлэн тавьж буй урьд хожид хийж байгаагүй томоохон өөрчлөлт, шинэчлэлтийг Үндэсний Номын сан дангаараа гүйцэтгэх боломжгүй. Тиймээс Номын сан зөвхөн мэдээллээр үйлчлүүлэгчдэд төдийгүй үндэсний бичиг соёлын өвийг хайрлан хамгаалж, баяжуулахад хувь нэмрээ оруулах хүсэл эрмэлзлэлтэй бүхий л мэргэжлийн болон бизнесийн байгууллага, номын сан, зохиогчидтой харилцан ашигтай хамтарч ажиллах арга зам хайна.

Номын сан одоогийн үйлчлүүлэгчдийнхээ хэрэгцээ шаардлагыг нарийвчлан судалж тэдэнд хүргэх үйлчилгээг чанаржуулахын хамт шинэ төрлийн үйлчилгээг нэвтрүүлснээр одоогоор хүрч чадахгүй байгаа:

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд
- Эмзэг бүлгийн хүмүүс (алслагдсан дүүргийн иргэд, суугуул иргэд)

- Тусгай байгууламжид байгаа (эмнэлэг, хорих газар г.м.) зэрэг хүмүүсийг хамрах болно.

Түүнчлэн гадаад дотоодын бизнесийн байгууллагууд, жижиг дунд үйлдвэрлэгчид, уул уурхайн компаниудад зориулсан өртөг шингэсэн захиалгат үйлчилгээг шинээр хөгжүүлнэ.

Бусадтай хамтран ажиллаж Номын санг хөгжүүлэх талаар Үндэсний номын сангийн дүрмийн 3.1.2, 3.2.8 болон 3.2.10-д "... байгууллагуудтай гэрээ байгуулж ажиллах, ...гадаад орны номын сангийн туршлагыг судалж нэвтрүүлэх, ...төсөл хөтөлбөрт оролцох, хамтран ажиллах" гэсэн тодорхой заалтууд байдаг. Энэхүү Стратегийг амжилттай хэрэгжүүлэхэд ивээн тэтгэгчид болон хамтарч ажиллах сонирхогч байгууллагуудын хамтын ажиллагаа маш чухал бөгөөд тэдгээрийг жагсаавал:

Ивээн тэтгэгчид:	Түншүүд:
- МУ-ын Засгийн Газар - БСШУЯ, Сангийн Яам - Кувейтийн буцалтгүй тусламж - Бизнесийн байгууллагууд - ЭСЯамд, гадаадын төсөл хөтөлбөр - Гадаадын мэргэжлийн байгууллагууд (IFLA, UNESCO, eIFL.net)	- МШХТ-ийн Газар (ICTA) - Номын сангийн Консорциум, - Гадаад, дотоодын номын сангууд - Ном хэвлэлийн үйлдвэр, хэвлэлийн газар - Үндэсний архив - Эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагууд - СУИС-ийн Соёлын дээд сургууль ШУТИС-ийн Холбоо Мэдээллийн сургууль - Үндэсний Оюуны өмчийн газар - Соёл урлагийн байгууллагууд - Монголын зохиолчдын хороо - Хэвлэл мэдээллийн байгууллагууд - ТББ

Ивээн тэтгэгчид Номын санг шинэчлэх дотоодын гол санхүүжилт БСШУЯ, Сангийн Яам болон Засгийн Газрын хөрөнгө оруулалтаас бүрдэх ба Номын сангийн шинэ байшин барих санхүүжилт Кувейтийн буцалтгүй тусламжаар хийгдэнэ. Өргөн цар хүрээтэй төслүүдийг хэрэгжүүлэхэд гадны санхүүжилт болон номын сангийн үйл ажиллагааг дэмждэг бизнесийн байгууллага, хувь хүмүүсийн дэмжлэг туслалцааг хайна.

Түншлэгчид Харилцан түншлэл нь үйлчилгээг сайжруулах нэг арга зам бөгөөд Номын сан нь үндэсний болон олон улсын түншлэгчидтэй холбоо тогтооно. Шуудан, Мэдээлэл Харилцаа Холбооны Агентлаг, Номын сангийн Консорциум, Оюуны Өмчийн газар, эрдэм шинжилгээ судалгааны байгууллагууд, Ном хэвлэл, архив, соёлын газрууд зэрэг нь Үндэсний хэмжээний гол түншлэгчид болно.

Стратегийн хүрээнд түншлэгч байгууллагуудтай Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурах, Хамтын ажиллагааны гэрээ байгуулах замаар одоо хэрэгжиж эхлээгүй байгаа:

- Дижитал номын сан бий болгох (агуулга, хүртээмж)
- Дижитал бүтээгдэхүүний хадгалалт хамгаалалтын стандартын тоног төхөөрөмж, сүлжээ бий болгох
- Дэлхийн шилдэг онлайн мэдээллийн сангуудыг хэрэглэгчдэд захиалж хүргэх
- Үндэсний нэгдсэн электрон каталоги хөгжүүлэх

- Үндэсний ховор болон үнэт номын хадгалалт, хамгаалалтыг олон улсын стандартын түвшинд хүргэх
- Боловсон хүчний чадамжийг системтэй сайжруулах чиглэлээр хамтран ажиллах зэрэг томоохон зорилтуудыг шийдвэрлэхийг хүсч байна.

Тухайлбал, нийтийн болон их дээд сургууль, судалгааны байгууллага, сонин сэтгүүлийн газар, үндэсний хэвлэн нийтлэлийн газруудтай хамтран эх хэл дээрх электрон агуулгын тусгай сангууд бүрдүүлэх чиглэлээр хамтарч ажиллана. Түүнчлэн хэвлэлийн газруудтай хамтран “Үндэсний баялагт ном хандивлах зарлиг”-ийг хэрэгжүүлэхэд дорвитой ахиц гаргаж уг зарлигийг заавал дагаж мөрдөх хууль дүрэм болгох талаар нөлөөллийн үйл ажиллагаа явуулахаас гадна Монголын номын сангийн зөв зохистой хөгжил, шинэчлэлтийн талаар БСШУЯ, Номын сангийн Консорциумтай хамтран орон даяар хэлэлцүүлэг эхлүүлнэ. Үндэсний архивын газар, музей, соёл урлагийн байгууллагуудтай түүхийн баримт, ховор үзмэр, урлаг соёлын онлайн сан бүрдүүлэх, сан хөмрөгийн үзэсгэлэн, урлаг соёлын арга хэмжээнүүдийг зохион байгуулна. Сан хөмрөгөө таниулан сурталчлах, соён гэгээрүүлэх чиглэлээр хэвлэл мэдээллийн байгууллагуудтай өргөн хүрээний харилцан ашигтай хамтын ажиллагаа тогтооно.

Стратегийн хамтын ажиллагааны үр дүнд Үндэсний номын сангийн үйл ажиллагаа шинэчлэгдэн сэргэж, Үндэсний номын сан болон хамтрагч байгууллагуудын нийгмийн хариуцлага өсч, тэдгээр байгууллагын үнэ цэнэ, нэр хүндийг нэмэгдүүлнэ.

1.4.3 Дижитал номын сангийн стратеги

Мэдээллийн эрин зуун дахь технологийн шинэчлэлт нь уламжлалт номын сангийн үйл ажиллагааны орчинг өөрчлөн шинэчилж, нэг талаас сан хөмрөгийг хэрэглэгчдэд илүү хүртээмжтэй болгохын хамт нөгөө талаас технологийн дэвшил ашиглан хялбар аргаар, хурдан шуурхай үйлчлэх боломжийг номын санд нээж байна. Жилээс жилд электрон хэлбэрээр гарах номын тоо өсөхийн хэрээр тэдгээрийг унших, ашиглах, хадгалах хэрэгслүүд шинэчлэгдэн улам боловсронгуй болж уншигчдад олон сонголттой бий болж байгаа энэ цаг үед Үндэсний номын сан шинэ Стратегийнхаа хүрээнд Дижитал номын сан бий болгож хөгжүүлэх зорилт тавьж байна. Дижитал номын сангийн төсөл нь программ хангамж, мэдээлэл буюу сан хөмрөг гэсэн хоёр хэсгээс бүрдэх ба сан хөмрөг нь электрон хэлбэрээр байна. Дижитал номын сан нь уншигчдад олон төрөл сэдвийн, сайтар боловсруулагдсан мэдээллийн сангаар үйлчлэх ба мөн зарим хэвлэмэл материалын электрон хувилбарыг хүргэх болно. Энэ стратегийг хэрэгжүүлэх явцад:

- хууль эрх зүйн зохицуулалт бий болгох (дижитал эрхийн менежмент)
- техник технологийн шинэчлэлт хийх (мэдээллийн технологийн дэд бүтэц)
- мэдээллийн аюулгүй орчин бүрдүүлэх

боловсон хүчний сургалт зайлшгүй шаардлагатай болно.

Үндэсний номын сан дүрмийнхээ дагуу хэвлэмэл ном цуглуулдагийн нэгэн адилаар электрон хэлбэрээр гарч буй чухал бүтээгдэхүүнийг ч сан хөмрөгтөө цуглуулж, хадгалах, хамгаалах, үйлчлүүлэгчиддээ хүртээх үүрэгтэй. Нөгөө талаас сан хөмрөгтөө байгаа үнэт, ховор номыг удаан хугацаанд хэрэглэгчдийн хүртээл болгохын тулд дижиталчилах ажил хийгдэж байгаа. Мөн гадаад, дотоодын томоохон онлайн мэдээллийн сан, электрон сонин сэтгүүлийг захиалах зэрэг бүхий л арга замаар дижитал сан хөмрөг бий болгож үйлчлүүлэгчиддээ хүргэхийг зорьж байна.

21-р зууны оюуны бүтээл хэрэглэгчиддээ ихэвчлэн онлайнаар дамжуулан түгээх хэлбэрээр бүтээгдэн, 20-р зууны Номын сан сан хөмрөгөө дижиталчилж нутаг орны аль ч өнцгөөс, өдөр шөнийн ялгаагүй ашиглах боломжийг дэлхийн улс орнууд аль хэдийн бүрдүүлж эхлээд байна. Тухайлбал, хойд хөрш Оросын Улсын төв номын сан 1995 оноос автоматжуулалтын ажиллагааг эхэлж өнөөдөр “Электрон номын сан Танд өөрөө хүрч очно”¹³ гэсэн уриатайгаар бүрэн онлайн үйлчилгээ үзүүлж байна. Хятад Улсын Үндэсний Номын сан Британийн болон Конгрессийн номын сантай хамтран зохиогчийн эрх нь хамгаалагдсанаас бусад бүх сан хөмрөгөө дижиталчилан өнгөрсөн есдүгээр сард тэмдэглэсэн 100 жилийнхээ ойн босгон дээр онлайнаар хэрэглэгчиддээ хүргэх гэж байгаагаа зарлав¹⁴.

Монгол Улсын Ерөнхийлөгч Бодлого үйл ажиллагааныхаа хөтөлбөрт “...эрдэм шинжилгээ, судалгааны чанарыг сайжруулахад чиглэсэн аливаа санал санаачилга, хөтөлбөр, үйл ажиллагааг дэмжиж ажиллана. Монгол хүн хаана ч амьдарч байсан ялгаагүй иргэний хувьд нийгмийн харилцаанд ижил тэнцүү оролцдог, шаардлагатай үйлчилгээг ялгаа заагүй авч чаддаг байхад анхаарна.”¹⁵ гэжээ. Номын сан түүн дотроо Үндэсний номын сан бол “үндэстэн өөрийн өнгөрсөн түүх болон ирээдүйд бүтээх зүйлээ хайж олдог—ой ухаанаа тэтгэж, бүтээх сэтгэх хүсэл мөрөөдлөө биелүүлж байдаг газар юм”¹⁶.

Манай орны нийгэм, соёл, улс төр, шашны бичиг соёлын үнэт зүйлс, Монголчуудын оюуны өв санг найдвартай хадгалан хамгаалж, арчлан тордож, хойч үедээ өвлүүлэн үе үеийн хэрэглэгчид үзэж судлах боломжийг Үндэсний номын сан олгодог билээ. Дижиталчиллын эринд уг номын сан доорхи дөрвөн гол зүйлийг хийх болно:

- Судалгаа, эрдэм шинжилгээний үнэ цэнтэй (trusted) онлайн мэдээллийн сангууд, сэтгүүл, сонин ашиглах өргөн боломжийг Монголчууддаа олгоно.
- Дижитал агуулга, түүний дотор эх хэл дээрх агуулгыг өргөн хүрээнд цуглуулна.
- Электрон хэлбэрээр гарсан Монголын оюуны бүтээлийг урт хугацаанд хадгалах, хамгаалах хэрэгслийн найдвартай байдлыг хангаж баталгаажуулна.
- Зохиогчийн эрхийг шалгаж баталгаажуулсан бүтээлийг дижиталчилах замаар сан хөмрөгийн хүртээмжийг эрс сайжруулна (enhance).

Одоо байгаа дижиталчилах техник хэрэгслээ өргөтгөн, хүн хүчээ нэмэгдүүлэх замаар Стратегийн хоёр дахь шатнаас дижиталчилах төвийг тус Номын санг түшиглэн байгуулж үйл ажиллагааны программ хангамж, хадгалалт хамгаалалтын асуудлыг олон улсын стандартын түвшинд хүргэнэ. Үндэсний номын сан дээр нэгэнт бий болсон дижитал сангуудыг бусад номын санд лицензээр ашиглуулах ажлыг туршина.


Дижитал номын сан бий болгох зорилтыг амжилттай хэрэгжүүлэхэд нэмэлт хөрөнгө оруулалт, бүтцийн шинэчлэлт, боловсон хүчнээ сургаж чадваржуулах зэрэг олон шинэ асуудлууд Номын сангийн өмнө тулгарах хэдий ч энэ төслийг хэрэгжүүлснээр номын сангийн ажиллагаа эрс сайжирч хөгжинө. Эцсийн дүндээ энэ далайцтай өөрчлөлт шинэчлэл нь номын сангийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хүчирхэгжүүлж сайжруулах гэсэн нийгмийн шаардлагатай нийцэж байгаа юм. (Бүлэг 2-ын Зорилт 4-ийг харна уу.).

1.4.4 Хүний нөөцийн хөгжлийн стратеги


Стратегийн хугацаанд Үндэсний Номын Санд:

- 2005 оны Засгийн Газрын тогтоолоор Үндэсний номын сан болгосон статусын хүрээнд хийгдэх бүтэц зохион байгуулалтын шинэчлэл (одоо хүртэл тогтоол хэрэгжиж эхлээгүй байгаа)
- Энэ Стратегийн хүрээнд хэрэгжих Дижитал номын сантай холбогдсон бүтэц зохион байгуулалтын шинэчлэл хийгдэх болно.


Номын сангийн одоогийн бүтэц



2016 ОНД БАТАЛСАН БҮТЭЦ



2016 онд баталсан шинэ бүтэц болон өргөтгөлд орохтой уялдсан номын сангийн ирээдүйн бүтэц



Номын сангийн одоогийн болон стандартын дагуу байвал зохих орон тоо

Хэлтэс нэгж, ажилтнуудын жагсаалт	Одоогийн орон тоо /2019 он/	Стратеги төлөвлөгөөний хугацаанд	Нэмэгдэх бүтэц, орон тоо
1.Хэлтэс, нэгж	5	6	1
2.Удирдах ажилтан	1	1	-
3.Гүйцэтгэх ажилтан /мэргэжлийн/	56	89	33
4.Туслах ажилтан	25	30	5
Нийт	82	120	38

Үндэсний Номын Сангийн одоогийн хүний нөөц социализмын үед хуучнаар ЗХУ-д мөн өөрийн орондоо мэргэжлийн сургууль дүүргэснээс хойш орчин үеийн шинэ технологи ашиглах, номын санд нэвтрүүлэх, дижитал агуулга бүрдүүлэх, тэдгээрийг боловсруулах, түгээх чиглэлээр дорвитой сургалтад хамрагдаагүй. Монгол, түвд, орос, солонгос, хятад хэлнээс өөр хэл дээрх мэдээлэлтэй ажиллах мэргэжилтэн өнөөгийн байдлаар байхгүй байна.

Шинэ бүтэцтэй холбогдон гарах хүний нөөцийн асуудлыг доорхи чиглэл баримтлан шийдвэрлэхээр төлөвлөж байна:

- Одоо ажиллаж буй мэргэжилтнүүдэд шаардлагатай байгаа чадамжийг бүрдүүлэх давтан сургалтад системтэйгээр хамруулах
- Шинээр ирэх ирээдүйн ажилтнуудын сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох чиглэлээр БСШУЯ-д санал боловсруулж оруулах, мэргэжлийн сургуулиудтай хамтарч ажиллах
- Мэдээллийн технологи, гадаад хэлний болон бусад шаардлагатай мэргэжилтнүүдийг татаж ажиллуулах бодлого баримтлах
- Авьяастай, чадвар туршлагатай хүний нөөцийн мэргэжилтэн, бизнесийн удирдагчдыг түр хугацаагаар тодорхой төслүүд дээр ажиллуулж, тэднээс суралцах
- Гадны номын сангийн мэргэжилтэн-зөвлөхөвч ажиллуулах
- Боловсон хүчний тогтвортой ажиллах эдийн засгийн болон сэтгэл санааны тааламжтай уур амьсгалыг бүрдүүлнэ.

Хүний нөөцийн хөгжлийн стратегийг хэрэгжүүлснээр дараах шинэ бүтцээр ажиллана. Хэлтэс нэгжүүд нь дор дурьдсан чиг үүргийг хүлээнэ.

Захиргаа үйлчилгээ, хангамжийн хэлтэс нь:

- Гадаадын орнуудын номын сангуудтай хамтын ажиллагаагаа улам өргөжүүлэх,
- Санхүү-төсвийн оновчтой төлөвлөж, зарцуулах

- Хүний нөөцийг хөгжүүлэх
- Номын сангийн аюулгүй ажиллагааг хангах,
- Тохижилт үйлчилгээ,
- Материаллаг баазаар хангах,

Мэдээлэл технологийн хэлтэс нь :

- Дижиталчлал шинэчлэлийг шат дараалалтайгаар хууль эрхзүйн хүрээнд хийж
дижитал сан хөмрөгийг бий болгох,
- Номын сангийн үйлчилгээний мэдээлэл технологийн дэд бүтцийг бий болгох,
- Мэдээллийн аюулгүй байдлыг хангах,
- Ном хэвлэлийг дижитал хэлбэрт оруулах лаборатори шинээр байгуулах,
- Гадаад дотоодын цахим сан материалыг бүрдүүлэх, архивлах, үйлчлэх,
- Онлайн үйлчилгээг нэвтрүүлэх,
- Номын сангийн холбогдолтой ном хэвлэл, гарын авлага, танилцуулга, урилга, хөтөлбөр,
сурталчилгааны материалыг бэлтгэх хэвлэх / Хэвлэлийн цех /

Ном хэвлэл сэргээн засварлах төв :

- Үнэт ховор ном судар, ном хэвлэлийн бүтэц, бүрэлдэхүүнийг судлах,
- Эртний ном судрыг технологийн дагуу сэргээн засварлах,
- Орчин үеийн ном хэвлэлийг сэлбэн засах,
- Сэлбэн засах чиглэлээр сургалт явуулах, дадлагын түшиц газар болох,

Арга зүй эрдэм шинжилгээний хэлтэс нь :

- Монгол Улсын Засгийн газрын тогтоолын дагуу мэргэжил арга зүйн Үндэсний төвийн үүргийг гүйцэтгэж, үйл ажиллагаагаа өргөжүүлэх,
- Үндэсний соёлын өв, сан хөмрөгийг хадгалах хамгаалах нэгдсэн бодлого болон сан хөмрөгийн онцгой байдлын үеийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх
- Номын санчид, ажилтнуудыг давтан сургах, мэргэшүүлэх уламжлалт болон онлайн сургалтыг тасралтгүй зохион байгуулах
- Ном, номын сан судлалаарх эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дэмжин хөгжүүлж, нэвтрүүлэх арга зүйг боловсруулах
- Гадаад, дотоодын ном хэвлэлийн байгууллагуудтай харилцан ажиллах, туршлага солилцох, туршлагыг дэлгэрүүлэх,
- Нийгэмд номын сангийн гүйцэтгэх үүрэг, ач холбогдлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан таниулах,

Ном бүрдүүлэх, боловсруулах, солилцох хэлтэс нь :

- Үндэсний номын сангийн архивын фонд, монгол судлалын фонд болон бусад сан хөмрөгийн тухайн үеийн байдалд байнга судалгааг явуулах, гадаад, дотоодод шинээр хэвлэгдэн гарч буй төрөл бүрийн хэвлэлийн бүтээгдэхүүнээс хэрэгцээт баримт, материалын эрэлт, сонголтыг хийх,
- Судалгааны үндсэн дээр номын сангийн чиг үүргийн дагуу гадаад, дотоодоос шаардлагатай хэвлэмэл ба хэвлэмэл бус баримт, материалуудыг тогтмол бүрдүүлэн, цуглуулах,
- Бүрдэгдсэн бүхий л баримт, материалуудад олон улсын стандарт, шаардлагад нийцсэн номын сангийн техник ажиллагаа, боловсруулалтыг хийж, архив, монгол судлалын болон бусад холбогдох фондуудыг баяжуулан, нийтийн хүртээл болгоход бэлдэх,
- Гадаадын номын сан, эрдэм шинжилгээний байгууллагуудтай ном, хэвлэл бүр солилцох ажлыг харилцан ашигтай байдлаар өргөжүүлэн явуулахын зэрэгцээ дотоодын номын сан, эрдэм шинжилгээний байгууллага, сургууль, албан газруудтай түр солилцооны гэрээт ажлуудыг эрхлэн явуулах,
- Номын санд заавал өгөх хувийн тухай Ерөнхийлөгчийн зарлигийг олон нийтэд сурталчлан таниулах,

Мэдээлэл номзүйн хэлтэс нь :

- Үндэсний номзүйг бэлтгэн гаргах, сурталчилах,
- Улсын нэгдсэн каталогийг бий болгох ажлыг эхлэн, хэрэгжүүлэх,
- Мэдээлэл номзүй лавлагааг төрөл бүрийн хэлбэрээр хэрэглэгчдэд хүргэх,
- Номын сан судлал, Ном, Номзүйн судалгаа, шинжилгээний ажлыг өргөжүүлэх,

Сан хөмрөг хадгаламжийн хэлтэс нь

- Ном хэвлэлийг зориулалтын орчинд хадгалах, хамгаалах,
- Төрөлжсөн сан хөмрөгөөр дамжуулан уншигч хэрэглэгчдэд ном, хэвлэл болон шаардлагатай мэдээллээр үйлчлэх,

Уншлага үйлчилгээний хэлтэс нь :

- Төрөлжсөн уншлагын танхимуудыг /Биеийн болон мэдрэхүйн дутагдалтай иргэдэд зориулсан танхим, хэвлэмэл бус материалын уншлагын танхим/ шинээр нээж үйлчлэх,

- Алслагдсан дүүрэг, аж ахуйн нэгж, албан байгууллагын захиалгаар болон тусгай байгууламжид буй /эмнэлэг, хорих газар/ номын сангаас гадуурх уншигчдад хүсэлтийн нь дагуу хүрч үйлчлэх,
- Шинэ технологид суурилсан онлайн үйлчилгээг тогтмол явуулах,
- Олон нийт, уншигч хэрэглэгчдийн сонирхолын судалгааг авч, судалгааны үндсэн дээр үйл ажиллагаагаа сайжруулж байх,
- Номтой нөхөрлөх талаарх соёл уламжлалыг сан хөмрөгөөрөө дамжуулан олон нийтэд сурталчлах төрөл бүрийн арга хэмжээг зохион байгуулах,

Номын санчдыг бэлтгэх, давтан сургахад төрийн бодлого, дэмжлэг юу юунаас чухал. Ажилтнуудын бүтээлч идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж чадваржуулах, шинэ чадвар эзэмших боломж олгоход хөрөнгө оруулах аваас Үндэсний Номын Сангийн сан хөмрөгийг таниулан мэдүүлэх, хадгалж хамгаалах, хойч үедээ өвлүүлэн үлдээх их үйлс бүтэж мэдлэгт суурилсан нийгмийг цогцлоох төрийн бодлого биеллээ олоход хувь нэмэр оруулах болно.

1.5 Стратегийн үр дүн

Ихэнхи хөгжиж байгаа болон хөгжингүй орнуудад Номын сангийнхаа хөгжлийг нийгмийн хөгжлийн чухал хүчин зүйл гэж тооцон орчин үеийн мэдээллийн технологийн ололт амжилтыг нэвтрүүлэн үйлчилгээ хүртэгсэд, үйлчилгээ хүргэгчдийн аль алиных нь ажиллагааг хөнгөвчлөн, үйлчилгээний хүрээг улам өргөн цар хүрээтэй, цаг хугацаанаас бага хамааралтай болгож байна. Түүнчлэн үйлчлүүлэгчид Номын санг ховор хуучин, үнэт ном хадгалж байдаг газар гэхээсээ илүү сурч боловсрох, судалгаа шинжилгээ хийх, шинэ туршлага судлах, бодлогын асуудлаар шинэ мэдээлэл олж авах, ер нь өөрт хэрэгцээтэй оюуны тэтгэлэг авах газар гэж нэгэнт хүсэн хүлээдэг болжээ. Үйлчлүүлэгчдийн энэхүү хэрэгцээ шаардлагыг хангаж чадаагүй тохиолдолд Номын сан бүрэн утгаараа үр өгөөжтэй ажиллаж байгаа гэж үзэх нь эргэлзээтэй.

Үндэсний номын сангийн хөгжлийн асуудлыг ийн цэгнэн үзэж боловсруулсан энэхүү Стратегийн хэрэгжүүлснээр Монголын хэрэглэгчид дараах үр ашгийг хүртэх болно:

- Хот, хөдөөгийн иргэд мэдээллийн технологийн суурь үйлчилгээ хүрсэн алс хязгаарын ямар ч аймаг, сум, дүүргээс Үндэсний номын сангийн үйлчилгээг авна.
- Эрдэмтэн судлаачид, их дээд сургуулийн оюутнууд гадаад орны байнга шинэчлэгдэж байдаг, найдвартай электрон мэдээллийн санг цаг хязгааргүй ашиглаж чадна.
- Нийтийн болон их дээд сургуулийн номын сангуудын дундын мэдээллийн сангууд бүрдэн тэдгээрийн үйл ажиллагаа нь үр ашигтай болохоос гадна үйлчилгээний чанарын шинэ стандарт бий болно.
- Улс орны хөгжлийн томоохон асуудал, цаг үеийн чухал сэдвээрх электрон сан бий болгосноор зөвхөн монголчууд төдийгүй гадаадын хөрөнгө оруулагчид баттай мэдээллийн эх үүсвэр ашиглах нөхцөл бүрдэнэ.

- Номын сангийн хөгжилд нэн шаардлагатай байгаа хууль эрх зүйн акт, стандарт, индикатор боловсруулагдан Монголын номын сангууд төдийгүй үйлчлүүлэгчид түүний үр шимийг хүртэх болно.

II БҮЛЭГ. Стратегийн хэтийн зорилго, эрхэм зорилго, зорилт, үйл ажиллагаа

2.1. Үндэсний номын сангийн хэтийн зорилго, эрхэм зорилго, зорилт, хүлээгдэж буй үр дүн

Vision / Хэтийн зорилго

Мэдлэгт суурилсан нийгэм хөгжүүлэхэд сан хөмрөг, үйлчилгээгээрээ гол хувь нэмэр оруулагч, манлайлагч байна.

Mission / Эрхэм зорилго

Соёлын өв, оюуны бүтээлийг цуглуулан баяжуулж, хадгалан хамгаалж, нээлттэй хүртээмжтэй мэдлэг мэдээллээр үндэстэндээ үйлчлэх, түгээх, хойч үедээ өвлүүлэн үлдээх

Стратегийн хүрээнд дэвшүүлж буй зорилтууд:

Зорилт 1. Үндэсний соёлын өв, оюуны бүтээлийн цуглуулгаа өргөжүүлэн баяжуулж, хадгалалт хамгаалалтын одоогийн нөхцлийг олон улсын стандартын түвшинд хүргэхийн хамт Монгол судлалын болон шинжлэх ухааны бусад өргөн хүрээний сэдвээр гадаад номын сан хөмрөгөө арвижуулж, шинэ технологийн тусламжтайгаар нийтэд хүртээмжтэй болгох, түгээн дэлгэрүүлэх ажиллагааг баталгаажуулна.

Энэ зорилтыг хэрэгжүүлэхийн тулд:

- Стратегийн эхний үе шатанд сан хөмрөгтөө судалгаа хийсний үндсэн дээр үндэсний соёлын өв, оюуны бүтээлийг баяжуулах, цуглуулах, хадгалж хамгаалах, түгээн дэлгэрүүлэх бодлого, арга замыг шинэчлэн тодорхойлж, хэрэгжүүлнэ.
- Үндэсний номын сангийн үүргийн дагуу Монгол Улсын чухал хэвлэмэл ба дижитал нийтлэлийн бүтээгдэхүүнийг сайн дураараа өгөх тухай Ерөнхийлөгчийн зарлигийг хэрэгжүүлэхэд уриалах, улмаар заавал авах хувийн тухай хууль эрх зүйн орчинг бий болгох асуудлыг Засгийн Газар, БСШУЯ- тай хамтран шийдвэрлэнэ.
- Монгол хэл дээрх дижитал агуулгын боломжит санг шинээр бүрдүүлэхийн хамт номын сангийн хэвлэмэл сан хөмрөгөөс дижиталчилах замаар электрон агуулгын санг бүрдүүлж эргэлтэнд оруулна.
- Гадаад оронд хэвлэгдсэн Монгол судлалын холбогдолтой болон бусад орон судлалын ном хэвлэл, судалгааны бусад материалыг бүрдүүлэх ажлыг өргөжүүлнэ.
- Гадаад ном хэвлэл болон цахим сан хөмрөгийг бүрдүүлэлтийн бүх хэлбэрийг ашиглан баяжуулна.
- МҮНС холбогдох байгууллагуудтай хамтран хараагүй болон сул хараатай иргэдэд ижил боломж олгох зорилгоор хэвлэмэл болон дижитал агуулга шинээр бүрдүүлнэ.

Зорилт 2. Номын сангийн уламжлалт үйлчилгээг чанаржуулж, хүртээх арга замуудыг боловсронгуй болгохын зэрэгцээ хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн нэмэлт үйлчилгээг нэвтрүүлж, номын сангийн сүлжээнд үндэсний мэргэжил, арга зүйн төвийн үүргээ үргэлжүүлэн гүйцэтгэнэ.

Энэ зорилтыг хэрэгжүүлэхийн тулд:

- Уламжлалт үйлчилгээг улам боловсронгуй болгож, Үндэсний номын сангийн үүрэг, зорилгод нийцүүлэн, хуримтлагдсан сан хөмрөгөө уншигчдын эрэлт хэрэгцээ, судалгаа шинжилгээнд тулгуурлан төрөлжүүлж, уншлагын танхимуудыг шинээр нээж ажиллуулна. (Номын сангийн шинэ бүтцийг харна уу.)
- Ханагүй үйлчилгээг үйлдвэр, албан байгууллага, алслагдсан дүүрэгт болон гэртээ болон тусгай байгууламжид байгаа (эмнэлэгт, хорих газар зэрэг) иргэдэд хүргэнэ.
- Шаардлагатай, тусгай хэрэгцээний сан хөмрөгийг шинээр бүрдүүлсний үндсэн дээр биеийн болон мэдрэхүйн дутагдалтай иргэдэд зориулсан үйлчилгээг шинээр нээн ажиллуулна.
- Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор батлагдсан Монголын номын сангуудад мэргэжил аргазүйн туслалцаа үзүүлэх үндэсний төвийн үйл ажиллагааг улсын хэмжээнд байгаа төрөл бүрийн номын сангуудыг хамруулан улам өргөжүүлнэ.

Зорилт 3. Засгийн газар, төрийн болон төрийн бус байгууллагууд, номын худалдаа, зохиогч, хэвлэн нийтлэгчид, хэвлэл мэдээллийнхэн, эрдэмтэн судлаачид, уншигч-хэрэглэгчид, бизнесийн бүлгүүд болон бусад сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд нийцсэн хамтын ажиллагааны шинэ загваруудыг эрэлхийлж, мэргэжлийн хүрээнд гадаад, дотоодын байгууллагуудтай стратегийн түншлэл үүсгэн харилцан ашигтай ажиллана.

Энэ зорилтыг хэрэгжүүлэхийн тулд:

- Засгийн газар, төрийн болон төрийн бус байгууллагууд, дотоодын номын сан, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтын ажиллагаагаа улам ойртуулж тодорхой төслүүд дээр үр ашигтай хамтран ажиллаж хамтарсан үйлчилгээний суурийг тавина.
- Иргэний нийгмийг хөгжүүлэхэд оруулах номын сангийн үүргийг нэмэгдүүлэн, номтой нөхөрлөх соёл уламжлалыг хөгжүүлэхэд анхаарч, сан хөмрөгөөр дамжуулан олон нийтэд сурталчлах төрөл бүрийн арга хэмжээг номын сангийн үйл ажиллагаа бүрт тусган хэрэгжүүлнэ.
- Эдийн засаг, нийгмийн хөгжилд оруулах номын сангийн үүргийг нэмэгдүүлэн, номын сан-бизнесийн байгууллага, хувийн секторын харилцан шүтэлцсэн холбоог хөгжүүлнэ.
- Номын сан нь мэдлэг мэдээлэл олж авах төдийгүй, өөр хоорондоо мэдээлэл солилцох, санаа бодлоо уралдуулах, мэдлэг мэдээллийн салбарт, нийгмийн сайн сайхны төлөө харилцан ашигтай, хамтарч ажиллах газар гэдгийг судлаачид, зохиогчдоос эхлээд төр, олон нийтийн болон бизнесийн салбарынханд мэдрүүлэх хамтарсан төслүүд хэрэгжүүлнэ.
- Гадаадын Үндэсний ба бусад номын сангууд, эрдэм шинжилгээний байгууллагуудтай харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлнэ.

Зорилт 4. Номын сангийн мэдээллийн технологийн дэд бүтцийг шинэчлэн сайжруулж, олон улсын стандартын түвшинд хүргэж, цахим

сан хөмрөг шинээр бүрдүүлснээр дижитал номын сангийн шинэ үйлчилгээг бий болгоно.

Энэ зорилтыг хэрэгжүүлэхийн тулд:

- Цахим үйлчилгээний тухай хууль эрхзүйн орчныг бүрдүүлнэ
- Номын сангийн дижитал үйлчилгээг найдвартай хүргэх мэдээллийн технологийн дэд бүтцийг бий болгож, мэдээллийн аюулгүй байдлыг хангах технологийн нөхцлийг бүрдүүлнэ.
- Хадгалагдаж буй сан хөмрөгөөс сонголттойгоор дижитал хэлбэрт шилжүүлэн, хэрэглэгчдэд үйлчилнэ.
- Гадаад, дотоодын цахим материалыг цуглуулах, хадгалах, архивлах, үйлчлэх, дэлхий дахинд онлайнаар нээлттэй танилцуулж, сурталчилна.

Зорилт 5. Номын сангийн шинэ бүтэц, технологид суурилсан шинэ үйлчилгээг дэмжиж ажиллах мэдлэг чадвартай хүний нөөц бий болгох чиглэлээр бусад сургалт, судалгааны байгууллага болон олон улсын номын сангуудтай үр ашигтай хамтран ажиллаж чадварлаг, бүтээлч хамт олон бүрдүүлэхэд онцгойлон анхаарна.

Энэ зорилтыг хэрэгжүүлэхийн тулд:

- Үндэсний номын сан шинэ бүтцээр хүлээх үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлж, чанартай, шинэ үйлчилгээ үзүүлэхийн тулд одоо байгаа ажилтнуудынхаа мэдлэг чадварыг дээшлүүлэхийн хамт бидэнтэй ажиллах, мэдлэг чадвартай шинэ хүмүүсийг татан ажиллуулна.
- Стратегийн зорилтыг хэрэгжүүлэхэд бидэнд дутагдах ажлын арга барил, мэдлэг чадварыг гадаад дотоодын давтан сургалтад хамруулан мэргэшүүлэхийн хамт, гадны зөвлөх авч ажлын байранд нь дадлагажуулж сургах замаар ажилтнуудаа чадавхижуулна.
- Ирээдүйн мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургахад мэргэжлийн болон технологийн чиглэлийн их, дээд сургуулиудтай хамтарч ажиллана.
- Удирдлагын түвшний ажилтнуудад зориулсан байгууллагын менежемент, маркетинг сурталчилгааны тусгай сургалтуудыг гадаад, дотоодын хамтран ажиллах байгууллагуудын тус дэмжлэгтэйгээр тодорхой давтамжтайгаар явуулах бодлого баримтлана.
- Ажилтан, албан хаагчдын нийгмийн асуудалд онцгой анхаарч, тав тухтай, тогтвор суурьшилтай ажиллах орчин нөхцлийг бүрдүүлнэ.

ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН

Үндэсний номын сан 2020-2024 оны Стратегийн зорилт, эрхэм зорилгоо бүрэн утгаар нь хэрэгжүүлж чадвал дараах өөрчлөлт шинэчлэлт, хөгжил дэвшил гарах болно.



2.2. Мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

Зорилго, зорилтууд	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хийж гүйцэтгэх хугацаа	Санхүүжүүлэх хэлбэр	Хариуцагч (байгууллага)
1. Үндэсний соёлын өв, оюуны бүтээлийн цуглуулгаа өргөжүүлэн баяжуулж, хадгалалт хамгаалалтын одоогийн нөхцлийг сайжруулж, Монгол судлалын болон шинжлэх ухааны бусад өргөн хүрээний сэдвээр гадаад номын сан хөмрөгөө арвижуулж, түгээн дэлгэрүүлэх				
1.1. Эхний үе шатанд сан хөмрөгтөө судалгаа хийсний үндсэн дээр үндэсний соёлын өв, оюуны бүтээлийг баяжуулах, цуглуулах, хадгалж хамгаалах, түгээн дэлгэрүүлэх бодлого, арга замыг шинэчлэн тодорхойлж, хэрэгжүүлнэ.	- Одоогийн сан хөмрөгийн бүтэц, бүрдүүлэлт, оюуны бүтээлийн хадгалалт хамгаалалтын байдалд судалгаа хийнэ. - Судалгааны үр дүнд сан хөмрөгтэй холбогдсон дараах бодлогыг шинээр болон шинэчлэн боловсруулж хэрэгжүүлнэ: - гар бичмэл, ном, хэвлэлийн сан бүрдүүлэх, хадгалж хамгаалах, түгээн дэлгэрүүлэх номын сангийн бодлого; - Хэвлэмэл сан хөмрөгөө улам чанаржуулах ба цахим санг шинээр бүрдүүлж нийтэд хүртээмжтэй болгох бодлого /шинээр/; - Сан хөмрөгийн онцгой байдлын үеийн бодлого /шинэчлэн/; - Номын сангийн өв санг хадгалж хамгаалахад тавигдах олон улсын стандарт шаардлагыг хангасан орчин, нөхцлийг өргөтгөл болон шинэ барилгад тусгуулна.	2020 оноос 2020 оноос 2020-2021 он	Улсын төсөв Улсын төсөв Улсын төсөв	БСШУСЯ, МУҮНС БСШУСЯ МУҮНС Бусад хамтран ажиллагсад БСШУСЯ, МУҮНС

	- “Ном хэвлэл сэргээн засварлах” лабораторийг өргөжүүлнэ.	2020-2021 он		БСШУСЯ, Сангийн яам МУҮНС
1.2. “Номын сангийн тухай хууль”-ийг хэрэгжүүлэхийн тулд Үндэсний номын санд заавал авах хувийн тухай олон нийтэд сурталчлан таниулах.	- Номын санд заавал өгөх бүтээлүүдийн хуулийг хэрэгжүүлж ажилладаг гадаад орнуудын номын сангийн туршлагаас судална. - Хэвлэх үйлдвэр, хэвлэлийн газар болон ISBN, ISSN дугаар олгодог байгууллагуудтай хамтран ажиллаж, Монгол улсад хэвлэгдсэн ном бүрээс Үндэсний номын сангийн архивт бүрдүүлэн, хадгалах. - Хуулийг хэрэгжүүлэхийн тулд дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ: - Оюуны бүтээл туурвигчид, хэвлэн нийтлэгчид, хэвлэлийн газрууд, номын сан, хэрэглэгчдийн хүртэх үр ашгийн талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчилна. - Зохиогчид, хэвлэн нийтлэгчид, хэвлэлийн газруудтай түншлэн ном, хэвлэл хандивлах үйл ажиллагааг сурталчлан таниулах, уулзалт ярилцлага зохион байгуулах зэргээр нөлөөллийн үйл ажиллагаа явуулна.	2020 оноос	Улсын төсөв	БСШУСЯ МУҮНС Бусад хамтран ажиллагсад

1.3 Монгол хэл дээрх цахим санг шинээр бүрдүүлэхийн хамт номын сангийн хэвлэмэл сан хөмрөгөөс тоон хэлбэрт оруулах замаар цахим санг бүрдүүлнэ.	- Монгол судлалын холбогдолтой гадаад, дотоодын хэвлэмэл номыг сканердан тоон хэлбэрт оруулна. - Сканнерт орсон гар бичмэл, барын ном, эрдмийн зэрэг хамгаалсан бүтээл болон ном, бусад баримтыг хянах, хард диск, серверт хуулж, архивлан хадгална. - Тогтмол хэвлэлийн цахим санг системтэй бүрдүүлнэ.	2020 оноос	Улсын төсөв, төсөл	МУҮНС, Бусад хамтран ажиллагсад
1.4 Гадаад оронд хэвлэгдсэн Монгол судлалын холбогдолтой болон бусад орон судлалын ном хэвлэл, судалгааны бусад материалыг бүрдүүлэх ажлыг өргөжүүлнэ.	- Монгол судлалын холбогдолтой монгол болон гадаад хэл дээрх мэдээллийн эх сурвалжуудыг төрөл бүрийн арга замаар эрэн сурвалжилж, судалгаа хийнэ. - Судалгааны үндсэн дээр холбогдох материалуудыг худалдаа, солилцоо, хандиваар бүрдүүлнэ. - Монгол судлалын холбогдолтой мэдээллийн сангуудтай холбоо тогтоож, ашиглах эрх авна.	2020-2021 он 2020-2024 он 2021 оноос	Улсын төсөв, төсөл	БСШУСЯ МУҮНС Бусад хамтран ажиллагсад
2. Номын сангийн уламжлалт үйлчилгээг боловсронгуй болгохын зэрэгцээ уншигч хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн нэмэлт үйлчилгээг нэвтрүүлж, номын сангийн салбарт үндэсний мэргэжил, арга зүйн төвийн үүргийг гүйцэтгэх				
2.1 Уламжлалт үйлчилгээг улам боловсронгуй болгож, Үндэсний номын сангийн үүрэг, зорилгод нийцүүлэн, хуримтлагдсан сан хөмрөгөө уншигчдын эрэлт хэрэгцээ, судалгаа шинжилгээнд тулгуурлан төрөлжүүлж, уншлагын танхимуудыг шинээр нээж ажиллуулна.	- Одоогийн үйлчилгээ болон технологийн шийдлийг үнэлж дүгнэн, үйлчилгээний шинэ хэлбэрүүд нэвтрүүлэх боломжит хөрөнгө нөөцийг тодорхойлно. - Номын сангийн өргөтгөлд орохтой холбогдон төрөлжсөн уншлагын танхим /цахим, төлбөрт үйлчилгээ ба бусад/-ыг өргөжүүлж ажиллана	2020 оноос 2020-2023	Улсын төсөв	БСШУСЯ, Сангийн яам, МУҮНС

2.2 Зөөврийн үйлчилгээг үйлдвэр, албан байгууллага, алслагдсан дүүрэгт болон гэртээ, тусгай байгууламжид байгаа иргэдэд хүргэнэ.	- Алслагдсан дүүрэг, аж ахуйн нэгж, албан байгууллага болон тусгай байгууламжид буй /эмнэлэг, хорих газар, асрамжийн газар/ зөөврийн номын сангийн үйлчилгээг идэвхжүүлнэ.	2020-2024 он	Улсын төсөв, төсөл, хандив	БСШУСЯ МУҮНС Бусад хамтран ажиллагсад
2.3 “Номын сангийн хууль”-ийн дагуу бусад номын санг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь дэмжлэг, туслалцаа үзүүлж, үйл ажиллагааг улам өргөжүүлнэ.	- Номын сан, ном хэвлэлийн үндсэн үйл ажиллагаанд мөрдөгдөх хууль эрхзүйн баримт, дүрэм, журам, гарын авлага боловсруулна. - Бусад номын санг эрдэм шинжилгээ-судалгаа, сургалт, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангана. - “Номын сангийн тухай хууль”-ийн дагуу номын сан судлал, ном судлал, номзүй судлалын чиглэлээр эрдэм шинжилгээ-судалгааны ажлыг гүйцэтгэнэ. - Номзүйн мэдээллийн хэрэглэгдэхүүн бэлтгэх, үндэсний номзүйг эрхлэн гаргана.	2020-2024 он	Улсын төсөв, төсөл, хандив	БСШУСЯ, МУҮНС, хамтрагч байгууллага
3. Засгийн газар, төрийн болон төрийн бус байгууллагууд, номын худалдаа, зохиогч, хэвлэн нийтлэгчид, хэвлэл мэдээллийнхэн, эрдэмтэн судлаачид, уншигч хэрэглэгчид, бизнесийн бүлгүүд болон бусад сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд нийцсэн хамтын ажиллагааны шинэ загваруудыг эрэлхийлж, мэргэжлийн хүрээнд гадаад, дотоодын байгууллагуудтай хамтран ажиллах				

3.1. Эдийн засаг, нийгмийн хөгжилд оруулах номын сангийн үүргийг нэмэгдүүлэн, Засгийн газар, төрийн болон төрийн бус байгууллагууд, дотоодын номын сан, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтын ажиллагаагаа улам ойртуулж тодорхой төслүүд дээр үр ашигтай хамтран ажиллаж хамтарсан үйлчилгээний суурийг тавина.	- Дотоодын номын сангууд болон түүх соёл, шинжлэх ухааны байгууллагуудтай хамтын ажиллагаагаа ном, хэвлэл солилцох, туршлага судлах, судалгаа шинжилгээ хийх зэргээр өргөжүүлж, сурталчилна. - Төрийн болон ТББ-ууд, бизнесийн бүлгүүд, хүмүүнлэгийн сайн дурын байгууллагуудтай хамтран төрөл бүрийн үйл ажиллагаа, хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ. - “Монголын номын сангийн консерциум”-тай цахим мэдээллийн санг бүрдүүлэх, боловсон хүчнийг чадваржуулах чиглэлээр хамтран ажиллана. - Хэрэглэгчид хэрэгцээт материалаа хялбар олж авахад нь туслах зорилгоор түнш байгууллага, сайн дурынхныг номын сангийн үйл ажиллагаанд татан оролцуулж, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлнэ.	2020 оноос	Улсын төсөв, төсөл	БСШУСЯ МУҮНС ба бусад
--	--	-------------------	---------------------------	----------------------------------

3.2. Иргэний нийгмийг хөгжүүлэхэд оруулах номын сангийн үүргийг нэмэгдүүлэн, номтой нөхөрлөх соёл уламжлалыг хөгжүүлэхэд анхаарч, сан хөмрөгөөр дамжуулан олон нийтэд сурталчлах төрөл бүрийн арга хэмжээг номын сангийн үйлчилгээнд тусган хэрэгжүүлнэ.	- Нээлттэй нийгмийг хөгжүүлэхэд номын сангийн сан хөмрөг, үйлчилгээний ач холбогдлыг нэмэгдүүлж, түүнийг сурталчилсан соёл, олон нийтийн арга хэмжээг тогтмол зохион байгуулна. - Нийгэмд номын сангийн гүйцэтгэх үүрэг, ач холбогдлыг хэвлэл, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр тогтмол сурталчлан таниулна. - Соёл уламжлал, бичиг үсгийг сурталчлах үйл ажиллагааг Үндэсний хөтөлбөрүүдтэй уялдуулан зохион байгуулна. - Гэр бүл, хүүхэд багачууд, ахмад настан болон олон нийтэд мэдээллийн үйлчилгээг хүргэхэд чиглэгдсэн төрөл бүрийн төсөл, хөтөлбөрийг дэмжинэ.	2020 оноос	Улсын төсөв, төсөл, хандив	БСШУСЯ МУҮНС, төрийн болон ТББ
3.3. Номын сан нь мэдлэг мэдээлэл олж авах төдийгүй, өөр хоорондоо мэдээлэл солилцох, санаа бодлоо уралдуулах, мэдлэг мэдээллийн салбарт, нийгмийн сайн сайхны төлөө харилцан ашигтай, хамтарч ажиллах газар гэдгийг судлаачид, зохиогчдоос эхлээд төр, олон нийтийн	- Хэрэглэгчид номын сангийн ажилтнуудтай эсвэл өөр хоорондоо харилцах боломж бүхий шинэлэг орчин, онлайн “орон зайг” бий болгоно. - Үйлчлүүлэгчдийн мэдлэг олох үйл ажиллагааг хөхүүлэн дэмжиж, оюуны бүтээлийг харилцан сурталчлах ажлыг олон нийтийн мэдээллийн	2020 оноос	Улсын төсөв, төсөл, хандив	БСШУСЯ МУҮНС, төрийн ба ТББ

	болон бизнесийн салбарынханд мэдрүүлэх хамтарсан төслүүд хэрэгжүүлнэ.	байгууллагуудтай хамтран тогтмол зохион байгуулна.			
3.4.	Гадаадын үндэсний ба бусад номын сангууд, эрдэм шинжилгээний байгууллагуудтай харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлнэ.	- Гадаад орны номын сан, эрдэм шинжилгээний байгууллагуудтай зөвхөн ном хэвлэл солилцох төдийгүй монгол орноо сурталчлах чиглэлээр сан хөмрөгөө танилцуулна. - Эртний цаас судлал, гар бичмэл ном судрыг сэргээн засварлах, хадгалж хамгаалах чиглэлээр ЮНЕСКО, Герман болон Зүүн хойд Азийн орнуудтай хамтран ажиллана. - Олон улсын байгууллагуудтай түншлэн цахим сангуудыг ашиглах эрх авах, төсөл хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллана.	2020 оноос	Улсын төсөв, төсөл, хөтөлбөр	БСШУСЯ, МУҮНС, олон улсын байгууллагууд
4. Номын сангийн мэдээллийн технологийн дэд бүтцийг шинэчлэн сайжруулж, олон улсын стандартын жишигт нийцүүлж, цахим үйлчилгээг бий болгох					
4.1.	Үндэсний номын сангийн цахим үйлчилгээний тухай хууль эрхзүйн орчныг бүрдүүлнэ	- Цахим үйлчилгээний тухай хууль эрхзүйн орчинг бүрдүүлэх чиглэлээр холбогдох яам, тусгай газар, Номын сангийн консорциум, Оюуны өмчийн газар зэрэг байгууллагатай хамтран ажлын хэсэг байгуулж дараах ажлуудыг хийнэ: - гадаад, дотоодын хууль, эрхзүйн баримтуудыг судлах;	2020 оноос	Улсын төсөв	БСШУСЯ, ХЗЯ, Оюуны өмчийн газар МУҮНС, Консорциум

	- Уулзалт, ярилцлага, хэлэлцүүлэг зохион байгуулах; - хууль, эрхзүйн баримтуудын төсөл боловсруулахад идэвхтэй оролцож номын сангийн үйлчилгээ ба зохиогчийн эрхийн асуудлаар санал боловсруулж холбогдох дээд байгууллагад уламжилж, нөлөөллийн үйл ажиллагаа явуулах; - Тоон хэлбэрт оруулсан ном хэвлэлийг бүрдүүлэх, архивлах, үйлчлэх журам боловсруулна.			
4.2. Номын сангийн цахим үйлчилгээг найдвартай хүргэх мэдээллийн технологийн дэд бүтцийг сайжруулж, мэдээллийн аюулгүй байдлыг хангах технологийн нөхцлийг бүрдүүлнэ.	- Одоо нэвтрүүлж буй “Коха” системийн модуль, каталогжуулалт, индикаторын судалгааг дуусгана. - Цахим үйлчилгээг нэвтрүүлэхэд шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг судалж сонгоно. - Мэдээллийн аюулгүй байдлыг хангах зориулалтын software, hardware-ийг судалж нэвтрүүлнэ.	2020-2024 онд	Улсын төсөв, төсөл	БСШУСЯ, МУҮНС, МТ-ийн хамтрагч байгууллагууд
4.3. Сан хөмрөгийг электрон каталогт үе шаттайгаар оруулах	- Хөрвөгдсөн бааз болох монгол номын ба диссертацийн засварын ажлыг бүрэн дуусгаж, электрон каталогийг онлайн сүлжээнд холбож нийтийн хүртээл болгоно. - Өрнө дахины сан хөмрөгийг оруулах төлөвлөгөө боловсруулан, хэрэгжүүлж эхэлнэ.	2020 онд 2020 он	Улсын төсөв Улсын төсөв	МУҮНС МУҮНС

	- Монгол судлал, гар бичмэлийн сан хөмрөгийг оруулах төлөвлөгөө боловсруулан, хэрэгжүүлж эхэлнэ. - ЮНЕСКО-гийн уншлагын танхим дахь баримт материалыг оруулж, нийтийн хүртээл болгоно. - АСИП төслийн хүрээнд хийгдсэн “Монгол лам нарын сүм бум”-ын мэдээллийн баазыг “Коха” системд хөрвүүлж, нийтийн хүртээл болгоно. - Номзүйн нэгдсэн электрон мэдээллийн сантай болно.	2020 он 2020 он 2020-2021 оноос 2020-2021 онд	Улсын төсөв Улсын төсөв, төсөл Улсын төсөв Улсын төсөв	МУҮНС МУҮНС, ЮНЕСКО, ЮНЕСКО-гийн МҮК МУҮНС, МТ-ийн байгууллагууд МУҮНС ба бусад номын сан
4.4. Хадгалагдаж буй сан хөмрөгөөс сонголттойгоор тоон хэлбэрт шилжүүлэн, хэрэглэгчдэд үйлчилнэ.	- Тоон системийн шинэчлэлийг шат дараалалтай хууль эрхзүйн хүрээнд хийж дараах цахим сан хөмрөгийг бий болгох ажлыг эрчимжүүлэх: - Монгол гар бичмэл ном судар; - Монгол судлалын холбогдолтой гадаад, дотоодын хэвлэмэл ном; - Өдөр тутмын тогтмол хэвлэлээс. - Ерөнхийлөгчийн нэрэмжит уншлагын танхимын үйлчилгээнд дижитал уншлагын системийг боловсронгуй болгож, цахим хэлбэрт орсон гар бичмэл номоор уншигчдад үйлчилнэ. - Цахим уншлагын танхимаар тоон хэлбэрт шилжсэн тогтмол хэвлэл, диссертац болон бусад материалыг	2020-2023 он	Улсын төсөв	МУҮНС

	уншигч хэрэглэгчдэд нээлттэй ашиглуулна.			
4.5. Гадаад, дотоодын цахим материалыг цуглуулах, хадгалах, архивлах, үйлчлэх үйл ажиллагааг эрчимжүүлнэ.	- Уншигч хэрэглэгчдийн хэрэгцээг судалсны үндсэн дээр гадаад дотоодын цахим материалыг: - бүрдүүлэх, хадгалах, архивлах ажлыг хэрэгжүүлж эхэлнэ. - монгол судлалын холбогдолтой мэдээллийн сангуудтай холбоо тогтоож, ашиглах эрх авч, хэрэглэгчдэд хүргэнэ. - уншигч хэрэглэгчдэд онлайнаар (номын сангийн вебсайт нь мэдээллийн портал сайт болно), уншлагын танхимаар нээлттэй танилцуулж сурталчилна.	2020 оноос	Улсын төсөв	БСШУСЯ, МУҮНС, төрийн ба ТББ-ууд
5. Номын сангийн шинэ бүтэц, технологид суурилсан шинэ үйлчилгээг дэмжиж ажиллах мэдлэг чадвартай хүний нөөц бий болгох чиглэлээр бусад сургалт, судалгааны байгууллага болон олон улсын номын сангуудтай үр ашигтай хамтран ажиллаж чадварлаг, бүтээлч хамт олон бүрдүүлэхэд онцгойлон анхаарах				
5.1. Номын сангийн өргөтгөлд орохтой холбогдон бүтэц зохион байгуулалтын шинэчлэл хийгдэх болно.	- Одоогийн ажиллаж буй хүний нөөцийн судалгааг нарийвчлан гаргаж, нэн тэргүүнд шаардлагатай боловсон хүчний орон тоог жил жилийн төсөвт тусгуулан батлуулж, нэмэгдүүлнэ.	2020- 2024 онд	Улсын төсөв	БСШУСЯ, Сангийн яам, МУҮНС
5.2. Үндэсний номын сан шинэ бүтцээр хүлээх үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлж, чанартай, шинэ үйлчилгээ үзүүлэхийн тулд одоо байгаа ажилтнуудынхаа мэдлэг чадварыг дээшлүүлэхийн хамт	- Мэдээллийн технологи болон гадаад хэлний өндөр боловсролтой чадварлаг боловсон хүчнүүдийг шаардлагатай үед хөдөлмөрийн гэрээгээр түр авч ажиллуулна.	2020- 2024 онд	Улсын төсөв, төсөл	БСШУСЯ, МУҮНС, гадаад, дотоодын мэргэжлийн ба сургалтын байгууллагууд

бидэнтэй ажиллах, мэдлэг чадвартай шинэ хүмүүсийг татан ажиллуулна.	- Одоо ажиллаж байгаа боловсон хүчнүүдийг: - Сургалт судалгаа - Цахим үйлчилгээ - Ном сэлбэн засах, сэргээн засварлалт - технологи, гадаад хэлний чиглэлээр ур чадварыг дээшлүүлэх сургалтыг гадаад, дотоодод үе шаттайгаар тасралтгүй зохион байгуулна. - Номын санчид болон СУИС-ийн оюутнуудын байнгын дадлага хийх түшиц газар болж өргөжинө.			
5.3. Ажилтан, албан хаагчдын нийгмийн асуудалд онцгой анхаарч, тав тухтай, тогтвор суурьшилтай ажиллах орчин нөхцлийг бүрдүүлнэ.	- “Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлага”, “Номын сангийн өв санг хадгалж хамгаалахад тавих шаардлага” зэрэг үндэсний болон олон улсын стандартыг хангасан тав тухтай орчинг бүрдүүлэхэд шаардагдах төсөв, хөрөнгийг жил бүрийн хөрөнгө оруулалт, улсын төсөвт тусгуулж, хэрэгжүүлнэ. - Үндэсний номын сангийн, ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулахын тулд нийгмийн асуудал, цалин урамшууллын системийг шинэчлэн боловсруулж шийдвэрлүүлнэ.	2020- 2024 онд	Улсын төсөв	БСШУСЯ, Сангийн яам, МУҮНС.

III БҮЛЭГ. МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ

3.1. Мастер төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт–шинжилгээ, үнэлгээ хийх ерөнхий зарчим

Монгол улсын Үндэсний номын санг 2020-2024 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөөг Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Монгол улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Төрөөс баримтлах соёлын бодлого, Соёлын тухай хууль, Номын сангийн тухай хуультай уялдуулан хэрэгжүүлнэ. Энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлэх хэрэгжилтийн явцыг хянаж үнэлэхэд БСШУСЯ, ҮНС-ийн Захиргааны зөвлөл, Номын сангийн мэргэжлийн зөвлөл, хэлтсүүд тодорхой үүрэг хариуцлага хүлээх бөгөөд дараах зарчмаар ажиллана:

- МУҮНС-ийн Мэргэжлийн зөвлөл нь хяналт, үнэлгээ хийхэд баримтлах шалгуур үзүүлэлт /Хавсралт 1, 2/ боловсруулж, БСШУСЯ-д танилцуулан бүрдүүлж шаардлагатай мэдээллээр хангах;
- Мастер төлөвлөгөөний зорилтуудын хэрэгжилтийг жил бүр үнэлж шаардлагатай нэмэлт өөрчлөлт оруулах, эх үүсвэрийг үр ашигтай хуваарилах талаар МУҮНС-ийн Мэргэжлийн зөвлөл санал дүгнэлтийг гаргах;
- Хөтөлбөр төслийн хэрэгжилтийг үнэлэхдээ МУҮНС-гийн үйл ажиллагааг шинэчлэхэд оруулсан хувь нэмэр, үр ашгийг гол үзүүлэлт болгох;
- Үр дүнгийн тайлан мэдээг гаргаж, оролцогч байгууллага, хандивлагчдад тараах.

3.2. Хяналт шинжилгээ, үнэлгээ хийх байгууллага, хугацаа

Мастер төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах, үе шат бүрийн төлөвлөлт, хяналт шинжилгээ, үнэлгээний байнгын үйл ажиллагааг МУҮНС-ийн холбогдох хэлтсүүд хариуцна.

Номын сангийн статистик мэдээллийн системд тулгуурлан мэдээллийг цуглуулах, бодлогын дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх, төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан мэдээ гаргаж БСШУСЯ, гүйцэтгэгч, хандивлагч байгууллага, олон нийтэд мэдээлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Мастер төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлж байгаа зорилтот хөтөлбөр, төслийн явцад хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг тухайн хөтөлбөр, төслийн зорилго, зорилт, арга хэмжээ болон хэрэгжүүлэх хугацаанаас хамааран төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон шалгуур үзүүлэлтийг үндэслэнэ.

Хяналт шинжилгээний явцад, стратеги төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх хугацаа, хүрэх эцсийн үр дүн, хуваарилагдсан хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулсан эсэх, төсвийн бус санхүүжилтийг ашигласан байдал, шинээр хөгжүүлсэн үйл ажиллагааны чанарт илүүтэй анхаарал хандуулна.

Хоёрдугаар хавсралт.
Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын
2008.12.30-ны өдрийн 155 тоот тушаалын хавсралт.

**Хоёр. Номын сангийн үйл ажиллагааг үнэлэх тоон шалгуур үзүүлэлтүүд,
дүгнэх аргачлал**

Ä/д	Үзүүлэлтүүд	Дүгнэх аргачлал	
1.	Мэргэжилтэй ажилтны хангалтын индекс / A_1 /	$A_1 = \frac{a_1}{a_2}$	a_1 - Мэргэжлийн номын санчдын тоо a_2 - Нийт номын санчдын тоо
2.	Мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдалтын индекс / A_2 /	$A_2 = \frac{a_3}{a_2}$	a_3 –Тухайн онд улсын чанартай мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдсан номын санчдын тоо
3.	Төсвийн зарцуулалтын индекс/ A_3 /	$A_3 = \frac{a_4}{a_5}$	a_4 - Төсвийн гүйцэтгэлийн хэмжээ a_5 - Батлагдсан төсөв
4.	Өөрийн үйл ажиллагааны орлогын индекс / A_4 /	$A_4 = \frac{a_6}{a_7}$	a_6 – Өөрийн үйл ажиллагааны орлого a_7 – – Өөрийн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө
5.	Сэргээн засварласан номын индекс / A_5 /	$A_5 = \frac{a_8}{a_9}$	a_8 - Сэргээн засварласан номын тоо a_9 - Сэргээн засварлахаар төлөвлөсөн номын тоо
6.	Номын фондын ашиглалтын индекс / A_6 /	$A_6 = \frac{a_{10}}{a_{11}}$	a_{10} – Олгосон номын тоо /давхардсан/ a_{11} –Фондонд байгаа номын тоо
7.	Номын үзэсгэлэн гаргалт / A_7 /	$A_7 = \frac{a_{12}}{a_{13}}$	a_{12} – Номын үзэсгэлэнгийн тоо a_{13} – Төлөвлөсөн номын үзэсгэлэнгийн тоо
8.	Ном, хэвлэлийн сурталчилгааны индекс A_8 /	$A_8 = \frac{a_{14} + a_{15} + a_{16}}{a_{17}}$	a_{14} – FM, радио болон телевизээр сурталчилсан тоо a_{15} – Сонин, сэтгүүл бусад хэвлэлээр сурталчилсан тоо a_{16} –вэб сайтаар сурталчилсан тоо a_{17} - Ном, хэвлэлийг сурталчлахаар төлөвлөсөн тоо